

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код: 45.020

Төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээ. Зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээний ерөнхий шаардлага	MNS 5876 : 2021
The service of railway passenger transport. General requirements for services in the passenger train and carriage of railway.	MNS 5876 : 2012-ын оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2021 оны ... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 2021 оны ... дугаар сарын ...-ны өдрөөс эхлэн хүчинтэй. Энэ стандартын шаардлагуудыг заавал мөрдөнө.

1 Зорилго

Энэхүү стандарттаар төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээний үйл ажиллагаа, чанарт тавих шаардлага, үйлчилгээний удирдлагын тогтолцоог оновчтой зохион байгуулан, зохицуулах ерөнхий шаардлагыг тодорхойлоход оршино.

2 Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт төмөр замын зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж буй **болон үйлчилгээний үйл ажиллагааг зохицуулахад оролцож буй төрийн болон хувийн, хувь нийлүүлж хамтарсан бүх байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд хамаарна. компанийн үйлчилгээний үйл ажиллагааг зохицуулахад болон төмөр замын зорчигч үйлчилгээний ажилтан, энэчиглэлээр суралцаагч, сонирхогч наарт хамраана.**

3 Норматив ишлэл

Энэ стандартыг боловсруулахад дараах хүчин төгөлдөр стандартуудыг ишлэл болгон ашигласан. Иш татсан стандарт нь дахин хянагдаж, нэмэлт өөрчлөлт орох, хүчингүй болох тохиолдолд хамгийн сүүлийн хэвлэлийг мөрдөнө. Үүнд:

- 3.1 Төмөр замын тээврийн тухай хууль.
- 3.2 Төмөр замын тээврийн үндсэн дүрэм.
- 3.3 Төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэм.
- 3.4 Олон улсын зорчигч харилцааны тухай хэлэлцээр.
- 3.5 MNS 4244 : 1994 Хөдөлмөр хамгааллын стандартын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага,
- 3.6 MNS 5833 : 2014 Төмөр замд барилга байгууламжийн ойртолтын болон хөдлөх бүрэлдэхүүний овор хэмжээ,
- 3.7 MNS 0900 : 2018 **Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ**
- 3.8 **MNS 4946:2019 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага**
- 3.9 MNS 4968 : 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага.
- 3.10 **MNS 4990 : 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны өрчин, эрүүл ахуйн шаардлага.**
- 3.11 **MNS 4996 : 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Ажлын байрны тээвэртүүлгийн норм, хэмжих арга ерөнхий шаардлага.**
- 3.12 MNS 4931 : 2000 Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага, ангилал.

- 3.13 MNS 4994 : 2000** Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй.
Дөргиөны норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага.
- 3.14 MNS 4244 : 1994** Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага.
- 3.15 MNS ISO 9001 : 2010** Чанарын удирдлагын төгтөлцөө тавих шаардлага
- 3.16 MNS ILO OSH 1 : 2003** Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны талаарх удирдамж.
- 3.17 MNS 5146 : 2002** Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй байдал Хамгаалах газардуулга, тэлэлт.
- 3.18 MNS 5147 : 2002** Хөдөлмөрийн аюулгүй байдал Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгаан статик орон. Ажлын байрны хүчлэгийн зөвшөөрөх түвшин. Хяналт тавих шаардлага.
- 3.19 MNS 5150 : 2002** Хөдөлмөрийн аюулгүй байдал Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Ерөнхий шаардлага;
- 3.20 MNS 5145 : 2002** Хөдөлмөрийн аюулгүй байдал. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Цахилгааны аюулгүй ажиллагаа. Хүрэх хүчдэл ба гүйдлийн зөвшөөрөх дээд түвшин.
- 3.21 MNS 5390 : 2004** Цахилгааны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага.
- 3.22 MNS 4978 : 2000** Аюултай ачааны ангилал. Техникийн ерөнхий шаардлага.
- 3.23 ISO 9001:2015.** Чанарын менежментийн тогтолцоо – Шаардлага.
- 3.24 ISO 22000:2018.** Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага.
- 3.25 ISO 45001.** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо.
- 3.26 ГОСТ Р 54750.** Рельсовые автобусы. Общие технические требования.

4 Нэр томьёо,

тодорхойлолт 4.1

Зорчигч

зорчигчийн галт тэргээр тасалбартайгаар зорчин аялах үйлчлүүлэгч.

4.2

Зорчигчийн гар тээш

жин болон оврын хувьд журамд заасан тогтоосон хэмжээнээс үл хэтрэх, зорчигчийн төлбөргүйгээр биедээ авч явж болох хувийн эд зүйлс.

4.3

Зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагаа

зэхэх, бэлтгэх, хүлээн авах, хадгалах, тээвэрлэх, буулгах зэрэг зорчигч, тээш тээвэрлэх үеийн зохион байгуулалт, технологийн харилцан уялдаатай цогцолбор ажил үйлчилгээг.

4.4

Зорчигчийн галт тэрэг

ажиллагаатай нэг буюу хэд хэдэн зүтгүүрт холбож найруулсан бөгөөд тогтоосон дохио бүхий зорчигчийн вагонуудаар найруулсан, зорчигч, тээш, шуудан тээвэрлэхэд зориулагдсан бүрэлдэхүүн.

4.5

Зорчигчийн вагон

зорчигч болон тээш, шуудан тээвэрлэхэд зориулагдсан зохих тоноглол бүхий

хөдлөх бүрэлдэхүүний нэгж.

4.6

Галт тэрэгний дарга

зорчигчийн галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй болоод техникийн бүрэн бүтэн байдал, галт тэрэгэн дэх соёлтой, шуурхай үйлчилгээг хариуцан галт тэрэгний цувааг шууд удирдан ажиллах ажилтан.

4.7

Вагоны үйлчлэгч

галт тэрэгний бүрэлдэхүүн дэх тухайн вагоны цэвэрлэгээ, зорчигч үйлчилгээг хариуцан, вагоны техникийн байдалд хяналт тавин, галт тэрэгний даргын шууд удирдлагад ажиллах ажилтан.

4.8

Галт тэрэгний засварчин- мастер

галт тэрэгний аялалын үед гарч болзошгүй техникийн гэмтлүүдийг хариуцан илрүүлж, засварлах үүрэгтэй бөгөөд галт тэрэгний даргын шууд удирдлагад ажиллах, түүний эзгүйд орлон ажиллах ажилтан.

4.9

Чиглэлийн самбар

галт тэрэгний бүрэлдэхүүн дэх вагонуудын аяллын замналыг заасан бичиглэл бүхий самбар.

4.10

Галт тэрэгний бүрэлдэхүүн дэх вагоны дугаар

галт тэрэгний бүрэлдэхүүн дэх вагоны байршлын дэс дугаар.

4.11

Вагон дахь суудлын дугаар

вагон дахь зорчигчийн байрлах байрын дэс дугаар.

4.12

Удирдлагын вагон

галт тэрэгний дарга байрлах, радио узел бүхий хөдлөх бүрэлдэхүүний нэгж.

4.13

Дээд зэрэглэлийн унталгын тасалгаат вагон

захиалагчийн хүсэлтээр дотоод зохион байгуулалт, тоноглол нь өвөрмөц хийцтэй, зорчигчийн аялалын тав тухыг дээд зэрэгээр хангах, цөөн тооны зорчигч тээвэрлэхэд зориулагдсан зорчигчийн вагон.

4.14

I зэрэглэлийн унталгын тасалгаат вагон

тус бүрт 2-оос дээшгүй зорчигч байрлах 9-өөс 10 тасалгаатай, нийт 20 хүртэлх тооны зорчигчийг тээвэрлэх зориулалт бүхий хөдлөх бүрэлдэхүүний нэгж.

4.15

II зэрэглэлийн унталгын тасалгаат вагон – гэж тус бүрт 3-аас 4 зорчигч байрлах 9-ээс 10 тасалгаатай, нийт 36 хүртэлх тооны зорчигч тээвэрлэх зориулалт бүхий хөдлөх бүрэлдэхүүний нэгж.

4.16

III зэрэглэлийн унтлагын вагон

тасалгаагүй, тусгаарлах ханаар 9 хэсэгт хуваагдсан, нэг хэсэгт 3 унтлагын ор, 3 унтлагын тавцан байх бөгөөд 6 зорчигч унтаж аялах боломжтой нийт 54 хүртэлх зорчигчийг тээвэрлэх зориулалт бүхий хөдлөх бүрэлдэхүүний нэгж.

4.17

Нийтийн вагон

тасалгаагүй, тусгаарлах ханаар 9 хэсэгт хуваагдсан, нэг хэсэгт 3 унтлагын ор, 3 унтлагын тавцан байх бөгөөд 9 зорчигч ээлжлэн амрах зориулалт бүхий нийт 81 хүртэлх зорчигч тээвэрлэхэд зориулагдсан хөдлөх бүрэлдэхүүний нэгж.

4.18

Суудлын вагон

хот дүүргийн хооронд аялах, зорчигчдод зориулсан хатуу болон зөөлөн суудлуудаар тоноглогдсон хөдлөх бүрэлдэхүүний нэгж.

4.19

Зорчигчийн вагоны ажлын тал

вагоны үйлчлэгчийн ажил, амралтын өрөө байрлах хэсэг.

4.20

Зорчигчийн вагоны ажилгүй тал

зорчигчийн вагоны үйлчлэгчийн ажил, амралтын өрөө байрлах хэсгийн эсрэг тал.

4.21

Тээш

тээврийн хэрэгсэлээр тусгайлан бэлтгэн авч явах ачаа. Тээш нь гар, ачаан гэж ангилагдах.

4.22

Гар-тээш

зорчигч биөдээ авч яваа эд зүйлс.

4.23

Ачаан тээш

тээшийн вагон болон галт тэргэнд хэмжээ, хийц, төрөл, зориулалтаараа ангилагдан, багцлагдан тогтоодсон тарифийн дагуу төлбөр төлөгдөн, хүрэх өртөө хүртэл цагийн хувиарийн дагуу тээвэрлэгдэх эд, бараа.

4.24

Итгэмжлэл

аливаа байгууллага, эсхүл хувь хүн нь тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх чадавхтайг нь эрх бүхий байгууллагаас тогтоож албан ёсоор хүлээн зөвшөөрөх ажиллагааг.

4.25

Нийлүүлэгчийн мэдэгдэл

үйлдвэрлэгч, эсхүл нийлүүлэгчээс бүтээгдэхүүнээ тогтоосон шаардлагад нийцэж буй талаар бичгээр мэдэгдэл гаргах ажиллагааг.

4.26

Үйлчилгээний чанар

байнга сайжруулж байх явцдаа хууль зүйн болон зохицуулалтын шаардлагад тохирох байдлыг хангах замаар үйлчлүүлэгчийн хэрэгцээ, сэтгэл ханамжийг дээшлүүлэх үйл ажиллагаа.

5 Зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч төмөр замын байгууллагад тавих ерөнхий шаардлага

5.1 Зорчигч тээврийн байгууллагын үйл ажиллагаа нь “ISO 9001. Чанарын менежментийн тогтолцоо – Шаардлага”, “ISO 45001. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо” стандартуудад нийцсэн байна.

5.2 Төмөр замын байгууллага нь зорчигчийн галт тэрэгний аяллын чиглэл, давтамж, бүрэлдэхүүн, цагийн хуваарийг зорчигч, үйлчлүүлэгчийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн зохион байгуулдаг байна.

5.3 Зорчих тасалбар, тээш, ачаан тээш тээвэрлэх болон бусад үйлчилгээний үнэ тариф нь нэн түрүүнд иргэдийн худалдан авах чадварт сууринсан байх бөгөөд зорчигч, үйлчлүүлэгчдэд үзүүлж буй үйлчилгээний чанартай бодитойгоор уялдсан байна. Үүний тулд төмөр замын байгууллага нь үнэ тарифт өөрчлөлт оруулсан тохиолдол нэг бүрийг холбогдох судалгаа, дүн шинжилгээгээр нотолж баримтжуулдаг байна.

5.4 Төмөр замын байгууллага нь зорчих тасалбарын үнийг вагоны зэрэглэлээс хамаарч харилцан ялгаатай тогтооно. Мөн 2 ба 3 дугаар зэрэглэлийн вагоны дээд ба доод суудлууд, 3 ба 4 дүгээр зэрэглэлийн нийтийн вагоны үндсэн ба хажуугийн суудлуудын зорчих тасалбарын үнэ харилцан ялгаатай байна. 4 дүгээр зэрэглэлийн нийтийн вагоны дээд суудал ба тээшийн тавиур дээр зорчих тасалбар бичихгүй.

5.5 Зорчигч тээврийн байгууллага нь зорчигч, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг жилд нэгээс доошгүй удаа авч дүн шинжилгээ хийн, холбогдох сайжруулалтыг төлөвлөн хэрэгжүүлж ажиллана.

5.6 Төмөр замын байгууллага нь зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүний явах анги, авто тоормос, ниших татах байгууламжийн зангилаа эд ангиудын техникийн үзлэг үйлчилгээг үндсэн, эргэлтийн ба завсрын өртөө бүрт, зорчигчийн вагонуудын урсгал засварыг аялал бүрийн хооронд үндсэн депод хийж гүйцэтгэх нөхцөлийг хангасан байна.

5.7 Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүний техникийн үзлэг үйлчилгээ, урсгал засвар нь “MNS 6466. Вагоны техникийн үзлэг, үйлчилгээ, засвар. Техникийн шаардлага” стандартад бүрэн нийцсэн байна.

5.8 Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүний сэлгээ, найруулга

5.8.1 Төмөр замын байгууллага нь үндсэн, эргэлтийн, завсрын өртөөд болон үндсэн депод зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүний сэлгээ, найруулгыг хийх нөхцөлийг хангасан байна.

5.8.2. Үндсэн депо ба үндсэн өртөө нь бүх чиглэлд аялдаг, эргэлтийн ба завсрын өртөөд нь тухайн чиглэлд аялдаг хамгийн урт бүрэлдэхүүнтэй зорчигчийн галт тэргэнд сэлгээ найруулгын үйл ажиллагаа явуулах дэд бүтцээр хангагдсан байна.

5.8.3. Сэлгээ, найруулгын ажлыг гүйцэтгэж буй байгууллага нь үйл ажиллагаандыа Монгол улсын Төмөр замын тээврийн тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан дүрэм, журам, эрх зүйн бусад акт баримт бичгүүдийг мөрдлөг болгон ажиллана.

5.8.4. Төмөр замын байгууллага нь зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүний сэлгээ, найруулгын ажлын технологийн нэгдсэн баримт бичгийг холбогдох эрх зүйн актуудад

нийцүүлэн баталж мөрдүүлнэ.

5.8.5. Зорчигч тээврийн байгууллага нь зорчигчийн галт тэрэгний аяллын чиглэл, вагоны тоо, төрөл, дугаарлалт, үндсэн, нэмэгдэл болон холбох салгах вагоны мэдээг багтаасан бүрэлдэхүүний схемийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаар батлуулж холбогдох журмын дагуу сэлгээ, найруулгын байгууллагад мэдээлж ажиллана.

5.8.6. Сэлгээ, найруулгын байгууллага нь олон улсын харилцааны галт тэргийг аялалд гарахаас 1 хоногийн өмнө, орон нутгийн галт тэргийг аялалд гарахаас гурваас доошгүй цагийн өмнө бүрэлдэхүүний схемийн дагуу найруулж бэлтгэсэн байна.

5.8.7. Зорчигчтой галт тэрэгний бүрэлдэхүүнд сэлгээ найруулга хийдэг (хийх) бол зорчигч нэг бүрийг уг асуудлаар даатгуулсан байна. Эс бөгөөс даатгалгүй зорчигчдыг вагоноос буулгаж, аюулгүй байрлалд шилжүүлсэн байвал зохино.

6 Зорчигчийн вагоны Төмөр замын буудлын үйлчилгээнд тавих өрөнхий шаардлага

6.1 Төмөр замын зорчигчийн вагоноос зорчигч буулгах, суулгах үйл ажиллагааг явуулдаг өртөө, зөрлөг, гүйцэж түрүүлэх газар, зогсоолуудад зорчигчдод үйлчилгэхэд зориулсан барилга, төхөөрөмж байгууламж, үйлчилгээний цэг нь архитектурын дагуу бүтээгдсэн, стандарт, дүрэмд нийцсэн, зорчигч тээвэрлэлтийн ая тухтай, хурдан, шуурхай үйлчилгээг үзүүлэн, аюулгүй байдлыг хангах иж бүрэн цогцолбортой байна.

6.2 Зорчигч үйлчилгээний цогцолбор нь MNS 5635 Төмөр замын буудал. Ерөнхий шаардлага стандартын шаардлагыг хангасан байна.

зорчигч үйлчилгээний барилга, тавцан, явган хүний нүхэн гарц, гүүр, хөндлөн гарц, өгсөх тавцан, тээш болон гар тээш хадгалах байр, шуудан, бараа бүтээгдэхүүн худалдаалах газар, тасалбар худалдаалах, суудал хувиарлах, лавлах үйлчилгээнд мэдээлэл хөлбөөны автомат системтэй, хяналтын видео төхөөрөмж, компьютерийн сүлжээ, ажлын автоматжуулсан байр, тээш ачих, буулгах, ажлын байр, тавцанг цэвэрлэх ажлыг механикуулагдсан байх.

6.3 Төмөр замын буудлын байшин, бусад барилга, байгууламжууд нь хамгийн ойр өрших замын тэнхлэгээс 20 м-ээс баагүй зайд, харин зорчигчийн галт тэрэг 140 км/цаг ба түүнээс их хурдтай явах шинэ шугамд 25 м-ээс баагүй, 50 м-ээс ихгүй зайд байрлах.

6.4 Зорчигч буулгаж суулгадаг бүх өртөө, зөрлөг, зэгсоол, гүйцэж түрүүлэх газарт зорчигчийн ондөрлөсөн болон нам тавцан нь ус зайлцуулах төхөөрөмжөөр тонөглөгдсөн, вагоны явах ангид хөөр талын үзлэг, засварыг хийх нохцлоор хангагдсан байх.

6.5 Зорчигчийн тавцангийн өргөний хэмжээг зорчигч урсгалын осолт, шинж чанар (алсын, хот хоорондын, хот дүүргийн), зорчигчийн галт тэрэгний хурд, тавцангас гарах гарцын байрлал, төө, тавцан дээрхи байгууламжийн (шат, павильон гэх мэт) хэмжээ зэргээс хамааруулан төгтоож, тахир тойруу хэсэгт байрласан өртөөний зорчигчийн ондөрлөсөн тавцан нь “Төмөр замд барилга байгууламжийн ойртөлтын болон хөдлөх бүрэлдэхүүний овр хэмжээ” MNS

5833: 2010 стандартын шаардлага хангасан байх.

- 6.6** ~~Өндөрлөсөн тавцантай зэрэгцээ орших гол замаар 140 км/цагаас дээш хурдтай зорчигчийн галт тэргийг зөгсөлтгүйгээр нэвтрүүлдэг өртөөн дээр тавцангийн өргөн нь хурдан галт тэргийг өнгөрөх явцад тавсан дээр байгаа хүмүүсийн /зорчигч тавцангийн захаас 3 м-ээс баагүй зайд байх/ аюулгүй байдлыг хангасан байх.~~
- 6.7** ~~Зорчигчийн тавсан дээр сүүдрэвч, явган хүнд зэриулсан гүүр, хөнгил руу орж өрц зэрэг байгууламж байрласан тохиолдойд байгууламжуудын захаас тавцангийн ирмэг хүртэл 2 м-ээс баагүй зайдай байх.~~
- 6.8** ~~Зорчигчийн галт тэрэг 140 км/цаг түүнээс дээш хурдтай явдаг шугамд байгууламжуудын захаас тавцангийн ирмэг хүртэлх зайд 3 м-ээс баагүй байх. Тавсан дээр зөхих журмын дагуу гэрэлтүүлэгийн шон болон бусад төхөөрөмж, байгууламж байрлуулах бол замын гол тэнхлэгээс 3,1 м-ээс баагүй байх.~~
- 6.9** ~~Зорчигчийн тавсан, парк, гарц, гарамын гэрэлтүүлэг нь Төмөр замын техник ашиглалтын дүрмийн 8.8 зүйлийг бүрэн хангасан байх.~~
- 6.10** ~~Зорчигчийн тавцангийн шал зам төмрийн толгойн түвшингээс дээш ондер, тавцангийн ирмэгээс замын тэнхлэг хүртэлх зайд нь “1520 мм царигтай төмөр замд барилга байгууламжийн ойртох хязгаар болон хөдлөх бүрэлдэхүүний овэр” MNS 5833 : 2010 стандартад нийцсэн байх.~~

7 Зорчигчийн галт тэрэг, вагон дахь үйлчилгээний нийтлэг шаардлага

- 7.1** Зорчигчийн галт тэрэгний үйлчилгээнд MNS ISO 9001:2010 стандартыг нэвтрүүлэн үйлчилгээний эрэлт, хэрэгцээ шаардлагад нийцсэн, чанар аюулгүй байдлыг хангасан үйлчилгээг үзүүлэх.
- 7.2** Зорчигчийн галт тэрэгний үйлчилгээнд MNS ISO 9001 Чанарын удирдлагын тогтолцооны шаардлага, MNS ISO 14001 Хүрээлэн буй орчны удирдлагын тогтолцооны стандартуудыг нэвтрүүлэн, хэрэгжүүлэн ажиллах.
- 7.3** Зорчигчийн галт тэрэгний үйлчилгээ нь Төмөр замаар зорчиж буй зорчигчдын аюулгүй байдлыг бүрэн хангасан байх.

- 7.4** Зорчигчдын тав тухтай байдлыг бүрэн хангах эд анги, тоног төхөөрөмж, техникийн хэрэгсэл бүхий хөдлөх бүрэлдэхүүнээр үйлчлэх.

- 7.5** Зорчигчдын гар тээш, тээш, ачаан тээшийн бүрэн бүтэн байдлыг хангах.

- 7.6** Галт тэрэгний үйлчилгээний ажилтан нь үйлчилгээний соёлын хэм хэмжээг баримтлан зорчигчдод соёлч боловсон, шуурхай, чанартай үйлчлэх.

7.7 Зорчигчийн вагоны ангилал

- 7.7.1** Зорчигчийн вагонуудыг дотоод зохион байгуулалт, бүтэц, зориулалтаас нь хамааруулан дараах байдлаар ангилна. Үүнд:

Вагоны ангилал	Тайлбар
- Дээд зэрэглэлийн	Захиалагчийн хүсэлтээр дотоод зохион

тасалгаат унтлагын вагон;	байгуулалт, тоноглол нь өвөрмөц хийцтэй, зорчигчийн аялалын тав тухыг дээд зэргээр хангах, цөөн тооны зорчигч тээвэрлэхэд зориулагдсан зорчигчийн вагон
- I зэрэглэлийн тасалгаат унтлагын вагон;	Тасалгаа тус бүрт 2-оос дээшгүй зорчигч байрлах, нийт 18 хүртэлх тооны зорчигчийг тээвэрлэх зориулат бүхий зөөлөн вагон
- II зэрэглэлийн тасалгаат унтлагын вагон;	Тасалгаа тус бүрт 4 зорчигч байрлах, нийт 36 хүртэлх тооны зорчигч тээвэрлэх зориулат бүхий тасалгаат вагон
- III зэрэглэлийн унтлагын вагон;	Тасалгаагүй, тусгаарлах ханаар хуваагдсан, нийт 54 хүртэлх зорчигчийг тээвэрлэх зориулат бүхий унтлагын вагон
- Нийтийн вагон;	Тасалгаагүй, тусгаарлах ханаар хуваагдсан, нийт 81 хүртэлх зорчигч тээвэрлэхэд зориулагдсан нийтийн вагон
- Суудлын вагон;	Хот дүүргийн хооронд аялах зорчигчдод зориулсан хатуу болон зөөлөн суудлуудаар тоноглогдсон хөдлөх бүрэлдэхүүний нэгж
- Зоогийн вагон;	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ үзүүлэх зориулалтаар тоноглосон хөдлөх бүрэлдэхүүний нэгж
- Тээшийн вагон;	Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд тээш, ачаан тээш тээвэрлэх зориулат бүхий хөдлөх бүрэлдэхүүний нэгж
- Тусгай үйлчилгээний зориулалтын вагон	Албаны болон техникийн, клубын, эмнэлгийн, туршилт хэмжүүрийн, лабораторийн гэх мэт тусгай үйлчилгээний зориулалтаар тоноглогдсон хөдлөх бүрэлдэхүүний нэгж

8 Зорчигчийн галт тэрэгний ангилал

8.1 Зорчигчийн галт тэргийг зориулалтаар нь:

- Зорчигчийн,
- Жуулчны,
- тусгай /төрийн болон албаны/

8.2 Зорчигчийн галт тэргийг харилцааны төрлөөр нь:

- Олон улсын (2 ба дээш улсын нутаг дэвсгэрийг дайран аялдаг),
- Орон нутгийн (Монгол улсын нутаг дэвсгэрийн хүрээнд аялдаг),

8.3 Зорчигчийн галт тэргийг аялаж байгаа мөрийн уртаас хэмжээнээс нь хамааруулан:

- Алсын аяллын (700 км-ээс дээш),
- Хот хоорондын (150 км-ээс 700 км),
- Хот дүүргийн (150 км хүртэлх),

8.4 Зорчигчийн галт тэргийг хурдаас нь хамааруулан:

- Ердийн галт тэрэг (100 км/ц хүртэлх хурдтай),
- Хурдан галт тэрэг (100 км/ц-аас 160 км/ц хүртэлх хурдтай),
- Хурдавчилсан галт тэрэг (160 км/ц –аас 200 км/ц хүртэлх хурдтай),
- Өндөр хурдны галт тэрэг (200 км/ц ба түүнээс дээш хурдтай)

8.5 Зорчигчийн галт тэрэг нь аялаж буй чиглэлээс нь хамааруулан:

- Тэгш чиглэлийн,
- Сондгой чиглэлийн гэж ангилна.

9 Зорчигчийн вагонд тавих техникийн шаардлага

9.1 Зорчигчийн вагоны техникийн бүрэн бүтэн байдал түүнд хийх засвар, үйлчилгээ нь “Зорчигчийн вагонд тавих техникийн ерөнхий шаардлага” стандарт болон түүнтэй холбоотой журам, заавар, технологийн шаардлагад бүрэн нийцсэн байх.

9.2 Зорчигчийн вагоны хийц, бүтэц зохион байгуулалт түүнд хийгдэх засвар үйлчилгээ, техник хэрэгсэл нь техникийн нөхцөл, норм, нормативын шаардлагыг бүрэн хангасан, зорчигчийн ая тухтай нөхцөлийг бүрдүүлсэн байх.

9.3 Зорчигчийн вагоныг хариуцан ажиллах ажилтан нар нь түүний техникийн хэвийн ажиллагаа, бүрэн бүтэн байдлыг хариуцан, ашиглалтын горим, дэглэмд найдвартай ажиллуулах чадвар бүрэн эзэмшсэн байх.

9.4 Зорчигч болон зорчигчийн вагонд ажиллаж буй ажилтан нарын эрүүл ахуй, ариун цэвэр, ая тухтай нөхцөл, шаардлагыг хангасан агааржуулалт, халаалтын системтэй, стандартын шаардлага хангасан вагоныг зорчигчийн галт тэргэнд холбож явуулах.

9.5 Зорчигчийн вагоны гадна үзэмж, өнгө, угаалга цэвэрлэгээ нь техникийн гоо зүйг хангасан байх ба аяллаас ирэх бурд вагоны гадна талын угаалга, цэвэрлэгээг зориулалтын тасагт, стандартын дагуу хийх.

9.6 Зорчигчийн вагоны хаалга, цонх нь хийцийн техникийн шаардлага болон стандартад нийцсэн ашиглалтын явцад зорчигч болон вагоны ажилтан нарийн аюулгүй, ая тухтай байдлыг бүрэн хангасан байх.

10. Зорчигчийн вагоны зэхэлтийн материал хэрэгслийн бэлтгэл, түгээлтэд тавих ерөнхий шаардлага

10.1 Зэхэлтийн худгийн бэлтгэл ба зорчигчийн вагоныг усаар зэхэх

10.1.1 Төмөр замын байгууллага нь үндсэн депо, үндсэн, эргэлтийн ба завсрын өртөөдөд зорчигчийн вагонуудыг хэрэглээний цэвэр усаар зэхэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

10.1.2 Цэвэр усны зэхэлтийн худгууд нь тухайн чиглэлд аялдаг хамгийн урт бүрэлдэхүүнийг зэхэхэд хангалттай тоо ба байршилтай байхын зэрэгцээ системийн дараалт нь 0.2–0.4МПа байна.

10.1.3 Ус нь “MNS 0900:2018. Үндны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” стандартад нийцсэн байна.

10.1.4 Төмөр замын байгууллага нь зэхэлтийн худгуудын усны чанарт Монгол улсын Эрүүл ахуйн тухай хууль, холбогдох эрх зүйн акт баримт бичгүүдэд тусгасан шаардлагад нийцүүлэн эрх бүхий байгууллагаар хяналт шалгалт хийлгэж баталгаажуулдаг байна.

10.1.5 Зорчигч тээврийн байгууллага нь зорчигчийн вагоныг усаар зэхэх технологийг холбогдох хууль, дүрэм, журам, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагуудад нийцүүлэн баталж мөрдүүлнэ.

10.2 Хатуу түлш, галлагааны хэрэгслийн бэлтгэл, түгээлт

10.2.1 Зорчигч тээврийн байгууллага нь халаалт ба үндны усны буцалгуурт хатуу түлш хэрэглэдэг вагонуудыг зохих түлшээр тасралтгүй хангах боломжийг бүрдүүлсэн байна.

10.2.2 Тасралтгүй хангах боломжид дараах нөхцөл байдлууд хамаарна. Үүнд:

- Үндсэн депо, эргэлтийн өртөө, шаардлагатай завсрыйн өртөөдөд хатуу түлшний нөөцийг бүрдүүлдэг байх;
- Дээрх цэгүүдэд хатуу түлшээр зэхэх хүн хүч, техник хэрэгслээр хангасан байх;

10.2.3 Түлээний мод хэрэглэж буй нөхцөлд модыг ус буцалгуурт багтажаар жижиглэж (20x5x5см) бэлтгэсэн, сэврээж хатаасан байна. Үртсэн болон түүнийг орлох шахмал түлш хэрэглэдэг бол үйлдвэрийн аргаар дээрх хэмжээгээр бэлтгүүлсэн байна.

10.2.4 Халаалтад хэрэглэх нүүрс ба түүнтэй адилтгах хатуу түлш нь 3500 ккал/кг-аас багагүй илчлэгтэй, нунтаг ба үл шатах хольцын агууламж 10%-аас ихгүй байна. Илчлэгийн дээд хэмжээг халаалтын зуухны онцлогоос хамааруулж зорчигч тээврийн байгууллага бие даан тодорхойлох ба технологийн баримт бичигтээ тусган мөрдөнө.

10.2.5 Зорчигч тээврийн байгууллага нь зорчигчийн вагонуудад хэрэглэгдэх хатуу түлшийг хадгалах тусгайлсан байгууламжтай байна.

10.2.6 Хатуу түлш хадгалах байгууламж нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Түлээний мод (уртсэн шахмал түлш) ба нүүрсийг тус тусад нь хадгалдаг байх;
- Хатуу түлшний чанарыг алдагдуулахаас сэргийлж тусгай барилга, эсвэл хашаа хаалт, хатуу хучилттай талбай бүхий саравчтай байх;
- Хатуу түлш татах, шилжүүлэн ачих зам талбайтай байх;

10.2.7 Төмөр замын байгууллага нь зорчигчийн вагоныг үндсэн депо, эргэлтийн ба завсрыйн өртөөдөд хатуу түлшээр зэхэх технологийг холбогдох хууль, дүрэм, журам, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагууд, эрх бүхий байгууллагаас баталсан норм, хэмжээнд нийцүүлэн баталж мөрдүүлнэ.

10.2.8 Зорчигч тээврийн байгууллага нь галлагааны хэрэгслийг хатуу түлшин халаалттай вагоны тоогоор бэлтгэж, галлагааны улирлын туршид хангана.

10.2.9 Галлагааны хэрэгсэл нь дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

- Галын дэгээ;
- Үнс нурамны хутгуур;
- Төмөр хувин;
- Лоом;

10.2.10 Зорчигч тээврийн байгууллага нь галлагааны хэрэгсэлд тавих шаардлагыг Монгол улсын Галын аюулгүй байдлын тухай хууль, Хөдөлмөрийн

аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актуудад нийцүүлэн тодорхойлж хангулна.

10.3 Цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийн бэлтгэл, түгээлт

10.3.1 Зорчигч тээврийн байгууллага нь унтлагын вагонуудыг ариутгасан цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлээр хангадаг байна.

10.3.2 Нэг зорчигчид үйлчлэх цагаан хэрэглэл нь дараах иж бүрдэлтэй байх ба иж бүрдэл тус бүрийг тусгайлан савлаж битүүмжилсэн байна. Үүнд:

- Дэвсгэр даавуу;
- Хучлага даавуу;
- Дэрний уут;
- Гар нүүрний арчуур;

10.3.3 Нэг зорчигчид үйлчлэх зөөлөн эдлэл нь дараах иж бүрдэлтэй байна. Үүнд:

- Дулаан хучлага;
- Зөөлөн дэвсгэр;
- Дэр;

10.3.4 Цагаан хэрэглэлийн хангалтад дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

- Нөөц бүрдүүлэх;
- Угаалга;
- Индуудлэг;
- Багцлалт;
- Хадгалалт;
- Түгээлт;

10.3.5 Цагаан хэрэглэлийн нөөц нь эргэлтийн ба бууршгүй гэсэн 2 төрөл байх ба эргэлтийн нөөц нь 5 хоногийн, бууршгүй нөөц нь 2 хоногийн зорчигч урсгалаас багагүй байна.

10.3.6 Зөөлөн эдлэлийн нөөц нь тухайн байгууллагын зөөлөн эдлэлээр зэхвэл зохих нийт вагоны буюу дээд, 1, 2, 3 дугаар зэрэглэлийн вагонуудын хэрэглээнээс 10%-аар их байна.

10.3.7 Зорчигч тээврийн байгууллага нь цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийн нөөцийг зориулалтын агуулахад хадгалдаг байна.

10.3.8 Цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийн агуулах нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Соролт-өгөлтийн механик агааржуулалттай;
- Агаарын температур тогтмол цельсийн 18 ± 2 градус;
- Агаарын харьцангуй чийгшилт 70%-аас ихгүй;
- Цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийг задгай болон багцалсан хэлбэрээр хадгалах зориулалтын тавиураар тоноглогдсон;

10.3.9 Төмөр замын байгууллага нь зорчигч тээврийн үйлчилгээнд ашиглах цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийн өнгө загвар, хэмжээ, материалын чанарт тавих шаардлагыг тодорхойлж хангулдаг байна. Мөн зорчигчийн вагоныг үндсэн депо,

эргэлтийн ба завсрын өртөөдөд цагаан хэрэглэл, зөвлөн эдлэлээр зэхэх технологийг холбогдох хууль, дүрэм, журам, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагуудад нийцүүлэн баталж мөрдүүлнэ.

10.3.10 Зорчигч тээврийн байгууллага нь зорчигчийн вагоны цагаан хэрэглэл, зөвлөн эдлэлийг давтан ашигладаг бол тэдгээрийн угаалга, халдвартгүйжүүлэлтийг Монгол улсын Эрүүл ахуйн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актуудад нийцүүлэн зохион байгуулдаг байна. Энэхүү шаардлагын хүрээнд уг байгууллага нь зорчигчийн вагоны цагаан хэрэглэл, зөвлөн эдлэлийн угаалга, индуудлэг, багцлалтын технологийг баталж мөрдүүлнэ.

10.3.11 Төмөр замын байгууллага нь цагаан хэрэглэл, зөвлөн эдлэлийн угаалгын чанарыг хэмждэг байх ба зорчигч үйлчилгээнд ашиглагдах цагаан хэрэглэл, зөвлөн эдлэлийн чанарын доод үзүүлэлтийг баталж мөрднө.

10.3.12 Цагаан хэрэглэл, зөвлөн эдлэлийн угаалгын газар нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Бөхир ба цэвэр гэсэн хоёр хэсэгт ангилагдсан, нэг чигийн урсгалтай байх ба бөхир хэсэгт – ашиглагдсан цагаан хэрэглэл, зөвлөн эдлэлийг ангилан ялгах, угааж халдвартгүйжүүлэх, цэвэр хэсэгт – угаагдсан цагаан хэрэглэл, зөвлөн эдлэлийг хатаах, индууддэх, багцлах үйл ажиллагаанууд явагддаг байна.
- Хэсэг тус бүр нь бие даасан аспирацын, эсвэл агааржуулалтын системээр тоноглогдсон байна.
- Угаалгын хэсгийн шал нь халтиргаа гулгаа үүсгэхгүй, ус чийг нэвчихгүй, цахилгаанждаггүй зориулалтын материалаар хийгдсэн байна. Шал, хана, тааз, хананы уулзвар ирмэг нь мохoo, хийц материал нь цэвэрлэхэд тохиромжтой байна.
- Угаалгын газрын өрөө тасалгаанууд нь 1 дүгээр хүснэгтэд заасан шаардлагыг хангасан байна. Үүнд:

1 дүгээр хүснэгт

Угаалгын газрын өрөө тасалгаануудад тавих шаардлага

№	Хэсэг		Гэрэлтүүлэг (Лк)	Харьцангуй чийгшилт (%)	Температур (°C)
1.	Бөхир хэсэг	Ангилан ялгах хэсэг	200	≤60	20±4
2.		Угаах хэсэг	150	≤70	20±4
3.	Цэвэр хэсэг	Хатаах хэсэг	100	≤50	20±4
4.		Индууддэх хэсэг	150	≤50	20±4
5.		Багцлах хэсэг	150	≤50	20±4

10.3.13 Зорчигч тээврийн байгууллага нь угаалга, индуудлэгийн техник тоног төхөөрөмжийн чадамжийг хоногт хэрэглэгддэг цагаан хэрэглэл, зөвлөн эдлэлийг угаах боломжоос 30% давахуйц хэмжээнд тооцож бүрдүүлсэн байна.

10.3.14 Индуудсэн цагаан хэрэглэл нь чийггүй, үрчлээ хунираасгүй, элдэв толбо, бохирдолгүй байна.

10.3.15 Зорчигч тээврийн байгууллага нь индуудсэн цагаан хэрэглэлээс улирал

тутам сорьц авч мэргэжлийн лабораторийн нян, мөөгөнцөр, хачиг, шимэгч илрүүлэх шинжилгээнд хамруулж халдвартгүйжүүлэлтийн чанарыг баталгаажуулдаг байна.

10.3.16 Цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийн угаалга, индуудлэг, багцлалтын үйл ажиллагаа эрхэлж буй байгууллага нь цахилгаан эрчим хүч тасалдах, ус хангамж, ариутгах татуургын байгууламжийн saat ал, техник хэрэгсэл доголдох, saat ал зэрэг эрсдэлүүдийг урьдчилан тооцож үйл ажиллагаа тасалдахгүй байх нөхцөлийг хангасан байна.

10.3.17 Төмөр замын байгууллага нь зорчигчийн вагоны цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийг галт тэрэгний бүрэлдэхүүнээс хураах, түгээх ажлыг цаг агаарын болон орчны нөлөөллөөс хамгаалах тусгайлсан уут эсвэл саванд хийж тусгайлан тоноглосон бүхээгтэй автомшинаар хийж гүйцэтгэдэг байна.

10.3.18 Зорчигч тээврийн байгууллага нь зорчигчийн вагоны цагаан хэрэглэл, зөөлөн эдлэлийг галт тэрэгний бүрэлдэхүүнээс хураах, түгээх технологийг баталж мөрдүүлнэ.

10.4 Дохиолол, мэдээллийн хэрэгслийн бэлтгэл, түгээлт

10.4.1 Зорчигч тээврийн байгууллага нь зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүн дэх вагон нэг бүрийг дохиолол мэдээллийн дараах хэрэгслээр хангадаг байна. Үүнд:

- а) Чиглэлийн самбар;
- б) Суух дугаар;
- в) Дохионы гар дэнлүү;
- г) Дохионы дарцаг;

10.4.2 Чиглэлийн самбарт тухайн галт тэрэгний аяллын чиглэлийг дараах байдлаар томьёолсон байна. Үүнд:

- 2 чиглэлд аялдаг бол [Үндсэн өртөө] – [Эргэлтийн өртөө] – [Үндсэн өртөө],
- 1 чиглэлд аялдаг бол [Үндсэн өртөө] – [Эргэлтийн өртөө]-ний нэр бүхий бичиглэлтэй байх.

10.4.3 Орон нутгийн галт тэрэгний чиглэлийн самбар нь зөвхөн Монгол хэлээр байна. Олон улсын харилцааны галт тэрэгний чиглэлийн самбар нь Монгол, Англи ба тухайн улсын хэлээр, гурван улс дайрч аялдаг бол тухайн 3 улсын хэлээр бичигдсэн байх ба үндсэн бичвэр нь Монгол хэлээр байна.

10.4.4 Чиглэлийн самбарын бичвэрийг гэрэлтэй, харанхуй аль ч нөхцөлд зорчигч, үйлчлүүлэгчдэд харагдахуйц байдлаар шийдвэрлэсэн байх ба үндсэн бичвэрийн үсгийн өндөр нь 12см-аас багагүй, бусад бичвэрийн үсгийн өндөр нь чиглэлийн самбарын талбайн хэмжээнээс хамаарч үндсэн бичвэрийн өндрийн 50%-аас багагүй байхаар тооцож байршуулсан байна.

10.4.5 Суух вагоны дугаар нь тухайн галт тэрэгний бүрэлдэхүүн дэх вагоны байршлыг илэрхийлэх ба араб тоогоор дугаарлагдана. Дугаарлалтыг явах чиглэлийн дагуу зүтгүүр талаас эхлүүлнэ.

10.4.6 Аяллын явцад завсрын болон эргэлтийн өртөөнөөс галт тэрэгний бүрэлдэхүүний эхэн ба дунд вагон байнга холбогддог нөхцөлд тэдгээр вагоны дугааруудыг алгасч суух вагоны дугаарыг олгоно.

10.4.7 Цаг үеийн гэнэтийн шийдвэрээр вагон холбох нөхцөлд бүрэлдэхүүний эхэнд нэг вагон холбох бол “0” дугаарыг, хэд хэдэн вагон холбох бол “0-1”, “0-2”, “0-3” гэх мэт тодотголыг нэмж дугаарлана. Бүрэлдэхүүний дунд хэсэгт вагон нэмж холбох нөхцөлд өмнөх вагоны дугаарын ард мөн адил тодотголыг нэмж дээрхийн адил дугаарлана.

10.4.8 Суух вагоны дугаарын бичвэр ба байршлыг гэрэлтэй, харанхуй аль ч нөхцөлд зорчигч, үйлчлүүлэгчдэд харагдахуйц байдлаар шийдвэрлэсэн байх ба үсгийн өндөр нь 16см-аас багагүй байна.

10.4.9 Дохионы гар дэнлүү нь шөнийн цагаар болон үзэгдэх орчин хязгаарлагдмал үед бүрэлдэхүүний сүүлийн вагоноос дохио өгөхөд машинчид харагдахуйц буюу 200–300Лк гэрэлтэлттэй, улаан ба шар хоёр өнгөөр гэрэлтдэг байна.

10.4.10 Дохионы дарцаг нь шар, улаан гэсэн 2 өнгийн байх ба дарцаг тус бүр нь 35x30см хэмжээтэй, иш нь 40–45см урттай, 1.5–2см диаметртай цилиндр, мод эсвэл хүйтэн орчинд гар хайрахааргүй бусад материалаар хийгдсэн байна.

10.5 Гал унтраах багаж хэрэгслийн бэлтгэл

10.5.1 Зорчигч тээврийн байгууллага нь зорчигчийн вагон нэг бүрийг “MNS 5566. Галын аюулаас хамгаалах аж ахуйн нэгж, байгууллага, барилга байгууламжид гал унтраах багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм” стандартын дагуу гал унтраах багаж хэрэгслийг бэлтгэж хангадаг байна.

11 Зорчигчийн галт тэрэг, вагонд тавих үйлчилгээний шаардлага

11.1 Үйлчилгээний үндсэн шаардлага

11.1.1 Төмөр замын зорчигч үйлчилгээний буудал, хүлээлгийн тэнхим, тасалбар түгээгүүр, мэдээлэл лавлагаа электрон, онлайн системд орсон байх ба шуурхай хүртээмжтэй байх түүний үйл ажиллагаа нь “Төмөр замын буудал. Ерөнхий шаардлага” зорчигчийн вокзалын үйлчилгээ стандарт, зааврын шаардлагад бүрэн нийцсэн байх.

11.1.2 Төмөр замын зорчигчийн вагоны үйлчлэгчийн үйлчилгээний ажлын технологи, зохион байгуулалт, чиг үүрэг, ажлын харилцан уялдаа, харилцааны соёл, уг хэллэг зэргийг бүтэн тусгасан заавартай байх ба түүнийг мөрдөж ажиллана. “Төмөр замын зорчигчийн вагоны үйлчлэгчийн заавар” т үйлчилгээний ажлын технологи, зохион байгуулалт, чиг үүрэг, ажлын харилцан уялдаа, харилцааны соёл, уг хэллэг зэргийг бүрэн тусгасан байх ба түүнийг мөрдөж ажиллах.

11.1.3 Төмөр замын зорчигч үйлчилгээний газар нь галт тэрэгний бригадын ажилтан нарт зориулсан ажлын хувцасыг солих өрөө, хадгалах шкаф, амрах байр, ном, сонин, сэтгүүл унших уншлагын тэнхим, гоо сайхан, усанд орох газар, ариун цэврийн үйлчилгээ авах цэг зэрэгтэй байх.

11.1.4 Зорчигчийн галт тэрэгний үйлчилгээний ажилтан нарийн мэдлэг, мэргэжил, чадал чадварыг дээшлүүлэн, хөгжүүлэх ажлыг **төмөр замын байгууллага** удирдан зохион байгуулж, гүйцэтгэх.

11.1.5 Төмөр замын зорчигч үйлчилгээний урамшуулалт, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгон “Вагоны үйлчилгээний ажлын чанар талон” -ыг нэвтрүүлэх.

11.1.6 Зорчигчийн вагоны дотор хаалганы дээд тал, коридорын хана, зорчих билет зэрэгт зорчигчийн вагоноор зорчих зорчигч нарт хүлээлгэх үүрэг хариуцлага, соёл, аюулгүй байдалтай холбоотой санамжийг боловсруулан байрлуулан сурталчилах.

11.1.7 Зорчигчийн галт тэрэг нь өөрийн тодорхой аялах чиглэл, дугаартай байх.

11.1.8 Зорчигчийн галт тэрэгний чиглэлийг түүний бүрэлдэхүүн дэх вагонуудын тэвшний хажуу хананы дунд хэсэгт тогтоож байрлуулсан самбар дээр бичсэн байх ба энэ нь “Зорчигчийн вагонд тэмдэг, тэмдэглэгээ бичлэг хийх” стандарт, журмын шаардлагад нийцсэн байх.

11.1.9 Галт тэрэг нь үндсэн өртөөнөөс 2 чиглэлд аялдаг бол вагоны чиглэлийн самбарт “**эргэлтийн өртөө-үндсэн өртөө-эргэлтийн өртөө**”-ний, 1 чиглэлд аялдаг бол “**үндсэн өртөө-эргэлтийн өртөө**”-ний нэр бүхий бичиглэл байх.

11.1.10 Зорчигчийн галт тэрэг нь урдаас хойшоо, зүүнээс баруун тийш чиглэн аялах бол сондгой тоон дугаартай, хойноос урагшаа, баруунаас зүүн тийш чиглэлтэй аялах бол тэгш тоон дугаартай байх.

11.1.11 Зорчигчийн галт тэрэг нь аялалд галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж, **ажилтан нар нь** зорчигчидод соёлч боловсон, шуурхай үйлчилгээг үзүүлэхээр бэлтгэгдэн, зэхэгдсэн байх.

11.1.12 Алсын аяллын болон урт бүрэлдэхүүнтэй зорчигчийн галт тэргэнд вагоны эд анги, зангилаа, систем, дотоод тоноглолын гэмтэлгүй байдлыг бүрэн хариуцах галт тэрэгний засварчин-мастер нь вагон ашиглалтын дүрэм, журам, заавар, технологийг мөрдөж, техникийн бүрэн бүтэн, найдвартай байдлыг ханган ажиллах.

11.1.13 Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүн дэхь вагонуудын байршилын дугаарыг дэс дараатай, чиглэлийн самбарыг төд, онго үзэмжтэй харагдахуйцаар **вагоны** хөөр талд тогтоон байрлуулсан байх.

11.1.14 Зорчигчийн галт тэрэгний цагийн хуваарийг суурь бүтэц эзэмшигч баталж бүх нийтэд тогтмол зарлан мэдэгдэж, галт тэрэгний хөдөлгөөнтэй холбоотой ажилтан нарыг цагийн хуваариар хангах.

11.1.15 Олон улсын харилцааны зорчигчийн галт тэрэгний хуваарийг хөрш орнуудын төмөр замуудын удирдах байгууллагатай зөвшилцсөнөөр тогтоон баталж, галт тэргийг цагийн хуваарийн дагуу аялуулах, бүх нийтэд тогтмол зарлан мэдэгдэх.

11.1.16 Үндсэн болон эргэлтийн өртөөнд галт тэргэнд зорчигч буулгалт, суулгалтыг харьяа төмөр замын аж ахуйн нэгжүүдийн технологит үйл ажиллагаа, зорчигч урсгалын хэмжээнд нийцүүлэн тогтоосон хугацаанд хийх ба завсрын өртөө зөрлөгт зурмагт заасан хугацаанд хийх.

11.1.17 Зорчигчийн вагоноос зорчигчийг буулгаж, суулгах завсрын өртөө, зөрлөг нь бүрэн тод гэрэлтүүлэгтэй, гарцтай, хөдөлгөөний болон зорчигчийн аюулгүй байдлыг бүрэн хангасан байгууламж, төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон байх ба **MNS 5635 Төмөр замын буудал**. **Ерөнхий шаардлага стандартыг хангасан байна.**

11.1.18 Шинэ загвар, хийцийн зорчигчийн вагон нь вакуум жорлонтой байх ба түүний ажиллагаа, арчилгаа нь галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, зорчигчийн ая тухтай байдлыг хангасан байх.

11.1.19 **Зорчигчийн вагон** вакуум жорлонгүй бол төмөр замын томоохон өртөө, зөрлөг, хотын бүс, амралт сувилал, гүүр, хонгилоор дайран өнгөрөх үед тэдгээр газруудад ирэх **болон** явснаас 15 минутийн өмнө, хойно ариун цэврийн өрөөг ашиглахыг хориглох ба вагоны үйлчлэгч нь уг өрөөг цоожилсон байх.

11.1.20 Ариун цэврийн өрөөний хаалганд галт тэрэгний аяллын чиглэл, зурмаг, дайран өнгөрөх өртөө, зөрлөг, хот суурин, тэдгээрийн ногоон бүсийг оруулж тооцсон, ажиллах цагийн хуваарь, шаардлагатай гэж үзвэл хүйс заасан ялгах тэмдгийг байрлуулсан байх.

11.1.21 Зорчигчдод эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан ариун цэврийн өрөөгөөр үйлчлэн түүний хаалганд байрлуулсан хуваарийн дагуу ажиллахыг **тэдэнд** мэдэгдэх.

11.1.22 Зорчигчийн вагоны ажилгүй талын үүдний хөнгилөөс бусад газарт тамхи татахыг хөриглөх. Зорчигчийн вагоны ажилгүй талын үүдний хөнгил нь тамхи татах бөлөх газар гэсэн тэмдэгтэй байхаас гадна үнсний саваар тоноглосон байх. Аяллын хугацаанд зорчигчийн вагон, жорлон, үүдний хонгилд тамхи татахыг хориглох.

11.1.23 Зорчигчийн вагонд зурагтын болон радио нэвтрүүлгийн үйлчилгээг тогтоосон цагийн хуваариар зорчигчдод үзүүлэх.

11.1.24 Зорчигчийн вагонд нэг талын аяллын үргэлжлэх хугацаанаас хамааран 1-2 вагоны үйлчлэгч ажиллаж, зорчигчдод үйлчлэх.

11.1.25 Зорчигчийн галт тэргэнд эмнэлэгийн анхан шатны тусlamжийн эмийн сан, гоц халдварт өвчний үед хэрэглэх иж бүрдлийг байнгын бэлэн авч явж, шаардлага гарсан үед зааврын дагуу ажиллуулж ашиглах.

11.1.26 Олон улсын харилцааны зорчигчийн галт тэрэгний вагонуудын суух дугаар нь хоёр талын хэлэлцээрийн протоколд зааснаар дугаарлагдах.

11.1.27 Олон улсын харилцааны зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд харилцагч талууд харилцан тохиролцож зоогийн вагоныг холбон аялуулах.

11.1.28 Олон улсын харилцааны зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд дээд зэрэглэлийн болон I, II зэрэглэлийн унлагын тасалгаат вагонуудыг холбон аялуулах.

11.2 Нэмэлт үйлчилгээнд тавигдах шаардлага

11.2.1 Зорчигчийн алсын аяллын болон олон улсын харилцааны галт тэргэнд зоогийн вагон холбогдон аялах ба MNS 4946 : 2019 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний

газарт тавих шаардлага, MNS 5021 : 2019 Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага, MNS 4588 : 2008 Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ - Зочид буудалд тавих ерөнхий шаардлага стандартын шаардлагыг хангасан байх.

11.2.2 I ба II зэрэглэлийн (дээд зэрэглэлийн) унтлагын тасалгаат вагонд зорчигч нь зоогийн вагонаас хоол захиалан, хүргүүлэн үйлчлүүлэх.

11.2.3 Зоогийн вагоны ажилчид нь техникийн аюулгүй байдал, зоогийн вагоны эрүүл ахуйн дүрэм, галын аюулгүй байдлыг дээд зэргээр хангаж ажиллах.

11.2.4 Зоогийн вагонд борлуулах хүнсний бүтээгдэхүүнүүд нь хүчин төгөлдөр мөрдөж буй холбогдох стандарт, эрүүл ахуйн шаардлагад бүрэн нийцсэн, хадгалах горимыг бүрэн хангах.

11.2.5 Галт тэрэгний зоогийн вагоны ажиллах цагийн хуваарь, түүний завсарлах хугацааг галт тэрэгний радио узелээр удирдлагын вагоны үйлчлэгч зарлаж зорчигчдод мэдээлэх.

11.2.6 Төмөр замаар тээш тээвэрлэх ажиллагаа нь “Төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрэм”-ийн шаардлагыг хангасан байх.

11.2.7 Тээшийн вагонд нэг вагоны үйлчлэгч, нэг ачаа түгээгч ажиллах.

11.2.8 Зөрчигчийн галт тэргэнд эмнэлэгийн анхан шатны тусламжийн эмийн сан, гөц халдварт өвчний үед хэрэглэх иж бурдлийг байнгын бэлэн авч явж, шаардлага гарсан үед зааврын дагуу ажиллуулж ашиглах.

11.2.9 Олон улсын харилцааны зорчигчийн галт тэрэгний вагонуудын суух дугаар нь хөөр талын хэлэлцээрийн протоколд зааснаар дугаарлагдах.

11.2.10 Олон улсын харилцааны зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд харилцагч талууд харилцан тохиролцож зөөгийн вагоныг хөлбөн аялуулах.

11.2.11 Олон улсын харилцааны зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнд дээд зэрэглэлийн болон I, II зэрэглэлийн унтлагын тасалгаат вагонуудыг хөлбөн аялуулах.

11.3 Зорчигчийн вагоны үйлчилгээний үндсэн багцын цай, көфений үйлчилгээ

11.3.1 Зөрчигчийн вагоны цайны хэрэгслийн хангалт зэхэлт. Үнд:

— Галт тэргийг аялалд гаражын өмнө вагонуудыг хүнсний эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, хэрэгцээний цай сахар, кофе, үйлдвэрийн нөхцөлд савласан цэвэр усаар зэхсэн байх;

— Цайны хэрэгсэл болох аяга, дийз, халбагыг тухайн вагоны зорчигчийн суудлын тоогтоор буюу түүнээс илүү хэмжээгээр зэхэх;

— Олон удаагийн цайны хэрэгслийг аялалд гаражын өмнө зөхих зааврын дагуу угааж ариутган хатаасан байх;

— Зорчигчийн вагоныг 100°C-ийн халуунд тэсвэртэй болон хагархай, эмтэрхий, хугархай бус аяга халбагаар зэхэж аялалд явуулах.

11.3.2 Зорчигч тээврийн байгууллага нь үйлчилгээний үндсэн ба нэмэлт багцын худалдан авалт, хадгалалт, түгээлтийн асуудлыг Монгол улсын Эрүүл ахуйн тухай

хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актуудад нийцүүлэн шийдвэрлэсэн байна.

11.3.3 Үйлчилгээний үндсэн багцад дараах зүйлс хамаарна. Үүнд:

- а) Цай;
- б) Кофе;
- в) Ус ундаа;
- г) Сахар;
- д) Нэг хэрэглээний аяга;

11.3.4 Цай, кофе, ус ундаа нь тус бүр 3-аас доошгүй төрлийн сонголттой байна.

11.3.5 Үйлчилгээний үндсэн багцын үйлдвэрлэгч нь “ISO 22000. Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо” стандартыг нэвтрүүлсэн байна.

11.3.6 Зорчигч тээврийн байгууллага нь зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүний вагон нэг бүрийг тухайн вагоны суудлын тооноос хоёр дахин их үндсэн багцаар зэхнэ.

11.3.7 Зорчигч тээврийн байгууллага нь үйлчилгээний үндсэн багцын 10 хоног, нэмэлт багцын 5 хоногийн нөөцийг тус тус бүрдүүлсэн байна.

11.3.8 Зорчигчийн вагоны цай, кофегоор зорчигчдод үйлчлэх. Үүнд:

- Цайны бүтээгдэхүүнүүдийг суурь /поднос/ дээр тавьж үйлчлэх,
- Вагоны үйлчлэгч нь аялалын аль ч үед зорчигчийн хүсэлтээр цай, кофе, усаар үйлчлэх,
- Зорчигчдод цайны бүтээгдэхүүнээр үйлчлэхдээ вагоны үйлчлэгч нь зориулалтын хормогч зүүсэн байх,

11.3.9 Зорчигчийн вагоны цайны хэрэгслийг ариутгаж цэвэрлэх. Үүнд:

11.3.9.1 Вагоны үйлчлэгчийн ажлын өрөө нь цайны хэрэгслийг хатаах, хадгалах зориулалттай тусгай ханын шүүгээгээр тоноглогдсон байх;

11.3.9.2 Зорчигчийн вагон нь цайны хэрэгслийг угааж цэвэрлэхэд зориулагдсан халуун, хүйтэн усны цорго бүхий угаалтуураар тоноглогдсон байх;

11.3.9.3 Цайны хэрэгслийг угааж ариутгахад зориулж галт тэргийг аялалд гарахын өмнө шаардлагатай ариутгалын бодис, шингэнээр зэхсэн байх ба зааврын дагуу хэрэглэх;

11.3.9.4 Угааж ариутгасан цайны хэрэгслийг зориулалтын шүүгээнд хатааж хадгалах.

11.3.10 Үйлчилгээний нэмэлт багцад аяллын үед зорчигчдод зонхилон шаардагддаг дараах үйлчилгээ хамаарна. Үүнд:

- а) Эрүүл ахуй, ариун цэвэр, ахуйн хэрэглээний бараа бүтээгдэхүүнээр үйлчлэх;
- б) Хүнсний бэлэн бүтээгдэхүүнээр үйлчлэх;
- в) Соёлын бараа бүтээгдэхүүнээр үйлчлэх;

11.3.11 Үйлчилгээний нэмэлт багцын “б”-д заасан бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэгч нь “ISO 22000. Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо” стандартыг нэвтрүүлсэн байна. Бусад бараа бүтээгдэхүүнүүд нь чанарын баталгааг нотлох баримт бичигтэй байна.

11.3.12 Зорчигч тээврийн байгууллага нь зорчигчдын хэрэглээнээс хамаарч зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнийг нэмэлт багцаар хангана.

11.4 Зорчигчийн вагоны орны хэрэгсэл, цагаан хэрэглэлийн үйлчилгээ нь

дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- 11.4.1 Зорчигчийн вагонд аялал бүрд стандартын шаардлага хангасан, ариутган цэвэрлэсэн ор дэрний хэрэгслээр бүрэн хангах,
- 11.4.2 Зорчигчийн вагоны орны хэрэгсэлд гудас, хөнжил /өдеяло/, орны бүтээлэг, дэр зэрэг хэрэгсэл орех,
- 11.4.3 Зорчигчийн унтлагын вагоны цагаан хэрэглэлд стандартын чанарын шаардлага хангасан хөнжлийн углаа уут, дэвсгэр даавуу, дэрний уут, нүүр гарын алчуурыг багцалсан байх;
- 11.4.4 Ариутгагдаж цэвэрлэсэн орны цагаан хэрэглэл, алчуур нь зорчигчдөд зөриулан тусгай нэг удаагийн уутанд багцалсан байх;
- 11.4.5 Багцалсан цагаан хэрэглэлд багцалсан газар, багцлагчийн нэр, багцалсан он сарыг бичсэн тооцооны хуудсыг хавсаргасан байх;
- 11.4.6 Зорчигчийн вагон тус бүрийг ижил хэлбэр, хэмжээтэй дан цайвар, нэг өнгийн цагаан хэрэглэлээр хангах буюу бэлтгэх,
- 11.4.7 Вагоны үйлчлэгч нь зорчигчдод аяллын тав хоног тутамд багц цэвэр цагаан хэрэглэлээр үйлчлэх,
- 11.4.8 Орны хэрэгсэл болох гудас, дэр, хөнжлийг цагаан хэрэглэлгүйгээр ашиглахыг хориглох,
- 11.4.9 Зорчигч өөрийн хүсэлтээр цагаан хэрэглэл ашиглахыг хүсэхгүй тохиолдолд вагоны үйлчлэгч нь орноос гудас, дэр, хөнжил, бүтээлгийг хураах,
- 11.4.10 Зорчигчийн ашигласан цагаан хэрэглэлийг үндсэн болон эргэлтийн өртөөнд ирэхээс 1 цагийн өмнө, завсрын өртөөдөд ирэхээс 30 минутийн өмнө шалгаж, хураан авч бохир цагаан хэрэглэлийн уутанд хураах,
- 11.4.11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настан болон бага насны хүүхэд харгалзах хүнгүй аялаж байгаа үед вагоны үйлчлэгч орыг нь засаж үйлчлэх. Бусад зорчигчдыг хүсвэл орыг нь засаж үйлчлэх,
- 11.4.12 Зорчигчийн вагон тус бүрийг ижил хэлбэр, хэмжээтэй, өнгө зурагтай зөвлөн эдлэлээр хангах, Цэвэр болон бохир цагаан хэрэглэлийг хамт хадгалахыг хориглоно.

11.5 Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүний аяллын өмнөх ба аяллын үеийн халаалт, хөргөлт-агааржуулалт

11.5.1 Зорчигчдод үйлчилж буй дээд, 1, 2, 3 дугаар зэрэглэлийн вагоны доторх агаарын температур цельсийн 24 ± 2 градус, 4 дүгээр зэрэглэлийн вагоны хувьд цельсийн 20 ± 2 градус байх бөгөөд бүх зэрэглэлийн вагоны агаарын найрлага нь "MNS 4585. Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага" стандартад нийцсэн байна.

11.5.2 Зорчигч тээврийн байгууллага нь зорчигчийн вагоны доторх агаарын температур, найрлага нь гадна орчны нөлөөллөөс үл хамааран тогтоосон хэмжээнд байх халаалт, хөргөлт, агааржуулалтын техникийн болон технологийн шийдлээр хангасан байна.

11.5.3 Галт тэрэгний ажилтан нь аялалд гарахаас өмнө болон аяллын туршид вагоны доторх агаарын дулаан ба найрлагыг тогтоосон хэм хэмжээнд байлгана.

11.6 Зорчигчийн вагоны аяллын өмнөх ба аяллын үеийн цэвэрлэгээ, халдвартгүйжүүлэлт

11.6.1 Зорчигч тээврийн байгууллага нь зорчигчдод үйлчилж буй вагоны доторх угаалга цэвэрлэгээ ба халдвартгүйжүүлэлтэд тавих шаардлага, хяналтын

тогтолцоог Монгол улсын Эрүүл ахуйн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актуудад нийцүүлэн баталж мөрдүүлнэ.

11.6.2 Зорчигчдод үйлчилж буй вагоны доторх цэвэрлэгээ ба халдвартгүйжүүлэлтэд тавих шаардлагын баримт бичигт дараах асуудлуудыг тусгасан байна. Үүнд:

- Вагоны хуурай цэвэрлэгээ;
- Ундны усаар хангах тоноглолуудын угаалга, цэвэрлэгээ ба халдвартгүйжүүлэлт;
- Давтан хэрэглээний сав суулганы угаалга, цэвэрлэгээ ба халдвартгүйжүүлэлт;
- Зорчигчийн ширээний угаалга, цэвэрлэгээ ба халдвартгүйжүүлэлт;
- Гарын угаалтуур, тосгуурын угаалга, цэвэрлэгээ ба халдвартгүйжүүлэлт;
- Ариун цэврийн суултуурын угаалга, цэвэрлэгээ ба халдвартгүйжүүлэлт;
- Ариун цэврийн өрөөний шалны угаалга, цэвэрлэгээ ба халдвартгүйжүүлэлт;
- Зорчих талбайн (шалны) угаалга, цэвэрлэгээ ба халдвартгүйжүүлэлт;
- Хана, тааз, цонх, орны угаалга цэвэрлэгээ ба халдвартгүйжүүлэлт;
- Хог хаягдлын ангилан ялгалт ба зайлувалт;

11.6.3 Олон улсын харилцааны зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүн нь эко ариун цэврийн байгууламжтай байна. Төмөр замын байгууллага нь эко ариун цэврийн байгууламжийн хураагуур савыг соруулах, халдвартгүйжүүлэх асуудлыг холбогдох эрх зүйн акт, гэрээ хэлэлцээрээр зохицуулсан байна.

11.6.4 Төмөр замын байгууллага нь орон нутгийн зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүнийг эко ариун цэврийн байгууламжаар бүрэн хангах асуудлыг хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөндөө тусган үе шаттайгаар хэрэгжүүлдэг байна.

11.7 Зорчигч, үйлчлүүлэгчийг угтан авах, үдэн гаргах үйлчилгээ

11.7.1 Зорчигч, үйлчлүүлэгчийг угтан авах, үдэн гаргах үйлчилгээнд дараах үйл ажиллагаа хамаарна. Үүнд:

- а) Зорчигч, үйлчлүүлэгчийг зорчигчийн тавцан дээр угтан авч вагонд оруулах, шаардлагатай тохиолдолд замчлах;
- б) Суудлаа эзлэх, гар тээшээ байршуулах чадваргүй зорчигчдод шаардлагатай тусламжийг үзүүлэх;
- в) Зорчигч, үйлчлүүлэгчдэд галт тэрэгний аяллын талаар танилцуулга мэдээлэл өгөх;
- г) Зорчигчдод тэдний буух ба шилжин суух өртөөнд хүрэх цаг, хангах бэлтгэлийн талаар мэдээлэл өгөх;
- д) Зорчигчийг зорчигчийн тавцан руу үдэн буулгах, шаардлагатай тохиолдолд тусламж үзүүлэх;

11.7.2 Зорчигч тээврийн байгууллага нь зорчигч үйлчлүүлэгчийг угтан авах, үдэн гаргах үйлчилгээний асуудлыг байгууллагын онцлог болон энэ стандартад нийцүүлэн холбогдох эрх зүйн актаар зохицуулсан байна.

11.7.3 Зохицуулалтын баримт бичигт зорчигч, үйлчлүүлэгчдийг угтан авах, үдэн гаргах үйлчилгээг хариуцах ажилтан, харилцах журам, өндөр настан, хөгжлийн болон хөдөлгөөний бэрхшээлтэй, асаргаа шаардлагатай зорчигчдод үйлчлэх асуудлыг

тусгасан байна.

11.8 Радио нэвтрүүлгийн үйлчилгээ

11.8.1 Зорчигчийн вагоны радио нэвтрүүлгийн техник, тооног төхөөрөмж нь бүрэн бүтэн, найдвартай хэвийн ажиллагааг хангасан байх,

11.8.2 Зорчигчийн галт тэрэгний зориулалт, аяллын чиглэл, зэрэглэлээс хамааран түүнд нийцсэн тусгай хөтөлбөрт радио нэвтрүүлэг нь монгол хэл болон шаардлагатай гадаад хэлээр нэвтрүүлэх,

11.8.3 Радио нэвтрүүлэг нь галт тэрэгний бүх вагонуудад бүрэн дамжуулан нэвтрүүлэх,

11.8.4 Зорчигч суулгалт хийж эхлэх мөчөөс радиогийн нэвтрүүлгийг нэвтрүүлсэн байх ба аялалын явцад өглөөний 06 цагаас хойш, үдшийн 22:00 цагийн хооронд завсарлагатайгаар, цагийн хуваарийн дагуу нэвтрүүлэх,

11.8.5 Радио нэвтрүүлгийн үйлчилгээг удирдлагын вагоны үйлчлэгч хариуцан ажиллуулах,

11.8.6 Радио нэвтрүүлэг нь батлагдсан тусгай хөтөлбөрийн дагуу байх,

11.8.7 Радио нэвтрүүлгийн хөтөлбөр нь шаардлагын дагуу шинэчлэгдэж, цаг үеийн оновчтой мэдээллийг нэвтрүүлэх,

11.8.8 Радиогийн сүлжээгээр дараах нэвтрүүлгүүдийг заавал нэвтрүүлэх. Үүнд:

- Үндсэн болон эргэлтийн өртөөнөөс галт тэрэг хөдөлж эхлэхэд галт тэрэг цувааны танилцуулгыг нэвтрүүлэх,
- Аяллын явцад давтамжтайгаар галт тэрэгний үйлчилгээ, зорчигчдийн аялах үеийн эрх, үүрэг,
- Галт тэрэгний хөдөлгөөний болон галын аюулгүй байдлын тухай,
- Галт тэрэгний цагийн хуваарь, зогсоолуудын талаархи мэдээллийг зорчигчдод өгөх,
- Зорчигчийн галт тэргээр зорчих зорчигчидод төмөр замаар зорчих дүрэм, сахилга, хариуцлагын талаар яриа танилцуулга хийх,
- Төмөр замын байгууллагын сурталчилгаат нэвтрүүлгийг нэвтрүүлэх,
- Бусад танин мэдэхүйн болон дуу хөгжмийн нэвтрүүлгүүдийг зорчигчдийн аялалын чөлөөт цагт зориулан нэвтрүүлэх.

11.9 Телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээ

11.9.1 Төмөр замын байгууллага нь зорчигчийн галт тэрэгний вагонд телевизийн нэвтрүүлгийн үйлчилгээг явуулах бол дараах шаардлагуудыг хангасан байвал зохино. Үүнд:

- Зорчигчдод зориулсан телевизийн нэвтрүүлгийг галт тэрэгний цагийн хуваарь, аялалын үргэлжлэх хугацаанаас хамааруулан тогтоосон цагийн хуваарийн дагуу нэвтрүүлэх,
- Телевизийн нэвтрүүлгийн хөтөлбөрт зорчигчдын зорчих нөхцөл, галт тэргэн дэх үйлчилгээний танилцуулга, галт тэрэгний хөдөлгөөний болон галын аюулгүй байдлын тухай санамж анхааруулга, галт тэрэгний зогсоолуудын талаархи мэдээллийг заавал тусгасан байх,

- Зорчигчдын аялалын чөлөөт цагт зориулж шинэ мэдээллийн хөтөлбөр, цаг агаар, зурхайн танилцуулга, хошин инээдмийн хөтөлбөр, спорт, сургалт, танин мэдэхүйн нэвтрүүлэг, хүүхэлдэйн кино, монголын болон гадаадын уран сайхны кинонууд, дуу хөгжмийн нэвтрүүлгүүдийг явуулах.

11.10 Интернет үйлчилгээ

11.10.1 Төмөр замын байгууллага нь зорчигчийн галт тэрэгний вагонд интернет үйлчилгээг явуулах бол дараах шаардлагыг хангасан байвал зохино. Үүнд:

11.10.1.1 Зорчигчийн вагонд байрлах интернетийн техник, хэрэгсэл нь бүрэн бүтэн үйлчилгээний шаардлага, техникийн хурдыг хангасан байх,

11.10.1.2 Интернет үйлчилгээ нь зорчигчдын ая тухтай байдлыг хангасан байх.

11.11 Явуулын хүнсний худалдааны үйлчилгээ

11.11.1 Зорчигчийн галт тэрэгний явуулын хүнсний худалдаа үйлчилгээнд дараах Шаардлагуудыг тавина. Үүнд:

11.11.1.1 Төмөр замын байгууллага, харьяа эрүүл мэндийн хяналтын газраас зөвшөөрсөн вагоны тасалгаанд явуулын хүнсний худалдааны үйлчилгээг явуулах,

11.11.1.2 Худалдаа эрхлэгч нь байр, орчны тохижолт ариун цэвэр эрүүл ахуй, бэлтгэн борлуулж буй хоол хүнсний чанар, аюулгүй байдлыг бүрэн хариуцах,

11.11.1.3 Худалдаалж буй бүтээгдэхүүндээ хүний эрүүл мэндэд аюулгүй гэсэн баталгааг шинэ бүтээгдэхүүн авсан тохиолдол бүрд, байнгын худалдаалах бүтээгдэхүүнд улирал бүр эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан байх,

11.11.2 Явуулын хүнсний худалдааны худалдаалах хүнсний бүтээгдэхүүнд тавих шаардлагууд. Үүнд:

11.11.2.1 Батлагдсан стандарт, эрүүл ахуйн шаардлага хангасан, чанарын баталгаатай барааг хүлээн авч худалдаалах,

11.11.2.2 Хүлээн авахдаа хайрцаг савны байдал хаяглалтыг шалган хайрцаг саван дээр үйлдвэрлэсэн огноо, хадгалах хугацаа, горим, жин, бүтэц зэргийг заасан шошготой байх,

11.11.2.3 Нөөцөлсөн бүтээгдэхүүн шил савтай бол биет байдлаа алдаагүй, төвийлт үүсээгүй, лаазалсан бол зэврээгүй, битүүмж алдагдаагүй хаяглалт нь бүрэн байх,

11.11.2.4 Полиэтилен уутанд жижиглэн савласан бүтээгдэхүүнийг худалдаа, хадгалах явцад гэрлийн шууд тусгалаас хамгаалж байрлуулах,

11.11.2.5 Түргэн муудах бүтээгдэхүүнийг хадгалах зөөврийн хөргүүртэй байх.

11.11.3 Явуулын хүнсний худалдааны үйлчилгээний ажилтны ажлын багаж хэрэгсэлд тавих шаардлага. Үүнд:

11.11.3.1 Хүнсний бүтээгдэхүүнийг таглаатай угааж цэвэрлэх боломжтой зориулалтын саванд хийж зөөвөрлөх,

11.11.3.2 Хоол ундаагаар үйлчлэх нэг удаагийн хэрэгсэл, аяга, таваг, халбага, сэрээгээр хангагдсан байх,

11.11.3.3 Худалдагч нь хавчаар, хутгуур, боодлын материалыг бэлэн байлгаж хэрэглэх,

- Сав баглаа боодол нь зориулалтын, эрүүл ахуйн шаардлага хангасан цаасан ба 0,25 мм-ээс доошгүй зузаантай полиэтилен уут байх ба сонин бусад зориулалтын бус сав, баглаа боодлыг хэрэглэхийг хориглоно.

11.12 Зорчигчийн галт тэргэн дэх аюулгүй байдлын үйлчилгээ

- 11.12.1 Аюулгүй байдлын үйлчилгээ нь галт тэргэнд илэрч болох гэмт хэрэг зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, вагонд нийтийн дэг журмыг сахиулахад чиглэгдэх,
- 11.12.2 Аюулгүй байдлыг хангах үйлчилгээний ажилтан нь галт тэргэнд тусгай байр эзлэн ажил үүргээ гүйцэтгэх,
- 11.12.3 Зорчигчийн вагоны аюулгүй болон бүрэн бүтэн байдал, ая тухтай нөхцөлийг алдагдуулсан тохиолдолд тогтоосон тариф дагуу торгуулыг оногдуулах.

12 Галт тэргэн дэх үйлчилгээний ажиллагсадад тавих шаардлага

12.1 Галт тэрэгний дарга

- 12.1.1 Галт тэрэгний дарга нь шинээр ажилд орохдоо ба цаашид ажиллах хугацаандаа тогтоосон хугацааны давтамжтай журмын дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд орсон байх,
- 12.1.2 Галт тэрэгний дарга дүрэмт хувцсанд тавих шаардлагын дагуу үлгэр жишээ хувцаслаж, үйлчилгээний ажилтныг Төмөр замын зорчигч үйлчилгээтэй холбоотой стандарт, журам, заавар, технологийг хэрэгжүүлэн ажиллах байдлыг хянан, зохицуулах,
- 12.1.3 Зорчигчийн галт тэргийг галт тэрэгний дарга удирдах ба галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдал, үйлчилгээний чанар, үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийг хөтлөн, бүртгэн тэдгээрийг бүрэн хариуцан ажиллах,
- 12.1.4 Галт тэрэгний дарга нь вагоны гэмтлийг тодорхойлох, засварлах дадлага туршлагатай, мэргэжлийн сургалт дүүргэсэн, удирдан зохион байгуулах чадвартай хүн байх,
- 12.1.5 Төмөр замын нэр төр, найрсаг нямбай байдлыг илэрхийлэхээр зорчигч үйлчилгээг зохион байгуулах,
- 12.1.6 Галт тэрэгний дарга нь тухайн Төмөр замын байгууллагын даргын баталсан “Ажиллах, амрах цагийн норматив ба гүйцэтгэх ажлын технологи”-ийн дагуу” ажил амралтаа зохицуулан ажиллах,
- 12.1.7 Олон улсын харилцааны галт тэрэгний дарга нь тухайн харилцагч орны хууль, эрх зүй болон хэлний зохих мэдлэгтэй байх,
- 12.1.8 Галт тэрэгний дарга нь ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргээ бүрэн биелүүлэхдээ Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Төмөр замын сарбарт мөрдөж буй стандарт, дүрэм, журам, заавар, тушаалыг чанд мөрдөн, өөрийн удирдлага доор байгаа ажилтан нарт мөрдүүлэн ажиллах,
- 12.1.9 Галт тэрэгний дарга нь ямагт зорчигчдыг хүндлэн найрсаг, боловсон харьцах.

12.2 Вагоны үйлчлэгч

- 12.2.1 Зорчигчийн вагоны үйлчлэгчид нь техникийн бүрэн бүтэн, аюулгүй байдал, зорчигчийн вагоны эрүүл ахуйн дүрэм, галын аюулгүй байдал, үйлчилгээний чанарыг хангаж ажиллах,
- 12.2.2 Вагоны үйлчлэгч нь шинээр ажилд орохдоо ба цаашид ажиллах хугацаандаа тогтоосон журмын дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдах ба үндсэн болон зэхэлтийн депо дээр эрүүл ахуйн тэнхимтэй түүнд үйлчилгээний ажилтан ирж эрүүл ахуйн анхан шатны үзлэгт ороод гарах боломжийг хангасан байх,
- 12.2.3 Вагоны үйлчлэгч нь зорчигчдийг хүндэтгэн найрсаг, эелдэг харьцаж, үйлчлэгчийн ажлын байрны тодорхойлолтод заасан ажил үүргээ бүрэн биелүүлж, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, тухайн төмөр замын хэмжээнд мөрдөж

буй хууль, дүрэм, стандарт, журам, заавар тушаалыг мөрдөн ажиллах,
12.2.4 “Зорчигчийн вагоны дарга, үйлчлэгчийн дүрэмт хувцсанд тавих шаардлага” журмыг тухайн төмөр замын байгууллагын үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн боловсруулан, мөрдүүлэн ажиллах,

12.2.5 Вагоны үйлчлэгч нь аяллын өмнө дүрэмт хувцас, эрүүл ахуйн хувцас, ажлын тусгай хувцсуудаа цаг улиралд нь тохируулан бүрэн бэлтгэсэн байх,

12.2.6 Вагоны үйлчлэгч нь ажил үүргээ биелүүлэх явцдаа гүйцэтгэж буй ажилдаа тохируулан найрсаг, цэвэрч нямбай байдал илэрхийлэхээр хувцасласан байх,

12.2.7 Вагоны үйлчлэгч нь гоёл чимэглэл, үс, хумсны засалт, нүүр будалт, гарын ариун цэвэр зэрэг гадаад төрхийг анхаарч, загвар засалтыг хэтрүүлэхгүй байх,

12.2.8 Тусгай болон олон улсын харилцааны галт тэрэгний вагоны үйлчлэгч нь мэргэжлийн ур чадвараараа шалгарсан, ажлын туршлагатай, ажлын хүрээнд шаардагдах гадаад хэлний зохих мэдлэгийг бүрэн эзэмшсэн байх,

12.2.9 Вагоны үйлчлэгч нь тухайн төмөр замын даргын баталсан “Вагоны үйлчлэгчийн ажиллах, амрах цагийн норматив, ба гүйцэтгэх ажлын технологи”- ийн дагуу ажил амралтаа зохицуулан ажиллаж, өөрийн мэдлэг, ур чадвараа байнга дээшлүүлж байх,

12.2.10 Вагоны үйлчлэгч нь үйлчлүүлэгчидэд чин сэтгэлээсээ хандан “Монголын төмөр зам”-ын төлөөлөгч байгаагаа ухамсарлан, ялгаварлалгүй адил тэгш, боловсон эелдэг харьцах.

13 Галт тэрэгний галын аюулгүй байдлын шаардлага

13.1 Галт тэрэгний вагонууд нь галын дохиоллын автомат систем, гал унтраах багаж хэрэгслээр зэхэгдсэн байх ба тэдгээр нь аяллын хугацаанд бүрэн найдвартай ажиллах,

13.2 Зорчигчийн галт тэрэг хоорондын замд гал гарах болон бусад аргагүйдэн зогсох үед хэрэглэх хааж хамгаалах хэрэгсэлийг стандартын шаардлагын дагуу авч явах ба ажилчид хэрэглэх, ашиглах чадварыг бүрэн эзэмшсэн байх,

13.3 Зорчигчидод вагонд галын аюулгүй байдлыг ханган зорчих, зөрчвэл хүлээлгэх хариуцлагын талаар таниулга, мэдээлэл тогтмол хийх,

13.4 Зорчигчийн вагонд галын аюулгүй байдлыг ханган ажиллахдаа MNS 4244 : 1994 “Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” стандартын шаардлагыг хангасан байх.

14 Тээш тээвэрлэхэд тавих шаардлага

14.1 Зорчигчийн вагоноор зорчих зорчигчийн тээш, ачаан тээш нь Төмөр замын тээвэрлэлтийн хууль, “Олон улсын зорчигчийн харилцааны хэлэлцээр”, “Олон улсын харилцааны зорчигчийн зорчигчийн вагон эдэлгээний дүрэм”, Төмөр замаар зорчигч, тээш, ачаан тээш тээвэрлэх дүрмийн шаардлага хангасан байх,

14.2 Зорчигчийн вагоноор зорчих зорчигч нь тогтоосон стандарт хэмжээстэй, жинтэй, хялбар шатдаггүй, тэсэрч дэлбэрэхгүй, химиин найрлагатай шингэн зүйлс биш, хурц ирмэггүй, хурц үнэргүй, галт зэвсэгийн чанартай биш гар тээшийг авч явах.

14.3 Ачаа, тээшийг зориулалтын техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдсон тээшний вагон болон галт тэргэнд хэмжээ, хийц, төрөл, зориулалтаар нь ангилан, багцлан, тээвэрлэлтийн норм, горийн дагуу тээвэрлэх,

14.4 Ачаа, тээшийг ачих, буулгах, ялгах, тээвэрлэх үйл ажиллагаа нь бүрэн автоматжуулагдсан байх,

14.5 Ачаа, тээшийг шилжүүлэн ачиж буулгах, бэлтгэн тээвэрлэх, хадгалах өртөөнүүд тэдгээрийн тэдгээрийн тээвэрлэлтийн горимд заасан стандартын шаардлага

хангасан хөргөлт, агааржуулалт, гэрэлтүүлэгтэй сав, агуулах, байртай байх.

ТӨГСӨВ.

**А.хавсралт
(норматив)**

А.1-р хүснэгт - Зорчигчийн тасалгаа болон вагоны үйлчлэгчийн өрөөний үндсэн хэмжээ

д/д	Үзүүлэлтийн нэр	Стандартчилах зүйлс						Үйлчлэгчийн купе	
		Вагоны зорчигчийн купе							
		Зөөлөн /1 хүний ортой/	Зөөлөн /2 хүний ортой/	купе	Унтлагын	2 давхар	Олон улсын ашиглалтанд		
1	Хаалганы хэмжээ, мм, багагүй: - Өндөр - Өргөн	1900 550	520 430 (сүүлийн купе)	-		1900 520 (430 сүүлийн купе)		1900 430	
2	Купены урт, мм, багагүй	2000	1900	-		1900		1675	
3	Унтлагын ор, мм, багагүй: - Урт - Өргөн	1840 700	1840 600	1665 580 (хажуугий н тавиур- 520)	1840	600		1665 (1515*)	
4	Шалнаас суух гадаргуу хүртэл өндөр, мм, багагүй			420					
5	Суух гадаргуугаас дээд унтлагын ор хүртэлхи хоорондын зайн өндөр, мм, багагүй		980			940			
6	Дээд унтлагын ороос тааз хүртэлхи хоорондын зайн өндөр, мм, багагүй		880	590 (тээшийн тавцан хүртэл)	600	780			
7	Унтлагын орны хоорондын зайн өргөн болон унтлагын ор коридорын өргөн			500					
ТАЙЛБАР: *нийтийн болон суух суудалтай вагонд									

A.2 – р хүснэгт - Тасалгаат вагоны стандарт хэмжээ

Зэрэглэл	Купены урт (тасалгааны гүйцэтгэлтэй)	Олон эгнээ суулгасан буйдан сандлын алхам	Бие бие рүүгээ харж байрлах буйдан сандлын байрлуулсан үед хоорондын зайд	Суудлын гүн	Суудлын өргөн (хамгийн их өргөнтэй хэсэгт) багагүй	Шалны түвшинд өндөр	Сандлын гарын тулгуур	
							Өргөн	Урт
зөөлөн	2100	1020-1300	850	500	500	430-аас бага	80	300
купе	1900	930-1020	700	460	480	450	50	
унтлагын		900-930	500	450(430)	400	450	50	

A.3-р хүснэгт- зорчигчийн вагон дахь доргионы түвшин

Октаавын зурвасны дундаж квадрат давтамж, Гц	Доргионы хурдатгалын норматив хэмжээ, м/с2	
	Чиглэл	
	Босоо	Хэвтээ
0,8		
1,0	0,22	0,10
1,2	0,20	0,10
1,6	0,18	0,10
2,0	0,16	0,10
2,5	0,14	0,12
3,15	0,25	0,16
4,0	0,11	0,20
5,0	0,11	0,25
6,3	0,11	0,31
8,0	0,11	0,40
10,0	0,14	0,50
12,5	0,18	0,63
16,0	0,22	0,80
20,0	0,28	1,00
25,0	0,35	1,25
31,5	0,45	1,60
40,0	0,56	2,00
50,0	0,71	2,50
63,0	0,9	3,15
80,0	1,12	4,00

А.4-р хүснэгт - Зорчигчийн вагон дахь инфра авиааны хязгаарын зөвшөөрөгдөх түвшингийн утгууд

Октаавын зурвасны дундаж геометр давтамж, Гц	Авианы даралтын зөвшөөрөгдөх түвшин, дБ
	Алсын аяллын вагонууд
2,0	99
4,0	96
8,0	93
16,0	93

В.хавсралт (норматив)**В.1-р хүснэгт - Вагон зэрэглэл ба ангилал**

№	Шаардлага	Вагоны зэрэглэл, ангилал									
		Дээд	I	II	III	Нийт-ийн	Суудлын	Зоогийн	Тээшийн	Тусгай	
0	1	2	3	4	5	6	7	8	9	10	
1. Гадаад хийц											
1.1	Гадна таних тэмдэг	Чиглэлийн самбар*	+/-**	+	+	+	+	+	+	+	-
1.2		Вагоны суух дугаар	+	+	+	+	+	+	-	-	-
1.4	Гадна дохио	2 талын сүүлийн дохио	+	+	+	+	+	+	+	+	+
1.5	Гадаад өнгө төрх	Вагоны гадна будаг	+	+	+	+	+	+	+	+	+
ТАЙЛБАР: * - чиглэлийн самбар дээрх бичиглэлийг кирилл үсгээр монгол хэл дээр, тодор бичсэн байна. ** - тусгай галт тэргэнд холбогдох үед чиглэлийн самбаргүй аялна.											
2. Дотоод хийц, тоноглол, систем											
2.1	Тасалгаа	+	+	+	-	-	-	-	-	-	+
2.2	Үнтлагын ор	+	+	+	+	+	-	-	-	-	+
2.3	Үнтлагын тавцан	-	-	+	+	+	-	-	-	-	+

Сандаартын 13ЛЭГ

ТАЙЛБАР: * - чиглэлийн самбар дээрх бичиглэлийг кирилл үсгээр монгол хэл дээр, тодор бичсэн байна.

** - тусгай галт тэргэнд холбогдох үед чиглэлийн самбаргүй аялна.

В1-р хүснэгтийн үргэлжлэл

2.4	Тээшийн тавцан	-	-	-	+	+	+	+	+	-
2.5	Усан хангамжийн систем	+	+	+	+	+	+	+	+	+
2.6	Агааржуулалтын төхөөрөмж	+	+	+	+	+	+	+	-	+
2.7	Салхижуулалтын төхөөрөмж	+	+	+	+	+	+	+	-	+
2.8	Халаалтын систем	+	+	+	+	+	+	+	+	+
2.9	Цахилгаан хангамжийн систем	+	+	+	+	+	+	+	+	+
2.10	Сав багаж хэрэгслийн агуулах, шүүгээ	+	+	+	+	+	+	+	+	+
2.11	Үнтлагын тавцанд авирах шат	-	-	+	+	+	-	-	-	+
2.12	Тасалгааны толь	+	+	+	-	-	-	-	-	+
2.13	Тасалгааны ширээ	+	+	+	+	+	-	-	-	+
2.14	Радио узел, түүний дууны тохируулга	+	+	+	+	+	+	+	+	+
3. Вагонд байх эд зүйлс										
3.1	Хогийн сав	+	+	+	+	+	+	+	+	+
3.2	Үнсний сав	+	+	+	+	+	+	-	+	+
3.3	Тоос сорогч	+	+	+	-	-	-	-	-	+
3.4	Хөргөч	+	+	+	-	-	-	-	-	+
3.5	Хувцасны өлгүүр	+	+	+	-	-	-	-	-	+
3.6	Телевизор	+	+	+	-	-	-	+	-	+
3.7	Хөгжим	+	-	-	-	-	-	-	-	+
4. Зорчигчдийн үйлчилгээнд зориулсан даавуун хэрэглэл										
4.1	Цонхны хөшиг	+	+	+	+	+	+	+	-	+
4.2	Гудас, гудасны уут	+	+	+	+	-	-	-	-	+
4.3	Дэр, дэрний уут	+	+	+	+	-	-	-	-	+

Стандарт, хэмжил зүйн газар.

Стандартын мэдээлэл, лавлагаа, сургалтын үндэсний төв. 2018-06-22
Хувилан олшруулахыг хориглоно.

B1-р хүснэгтийн үргэлжлэл

4.4	Орны бүтээлэг	+	+	+	+	-	-	-	-	+
4.5	Өвлийн хөнжил /одеял/	+	+	+	+	-	-	-	-	+
4.6	Нүүр гарын алчуур	+	+	+	+	-	-	-	-	+
4.7	Дэвсгэр ба нөмрөх даавуу	-	-	+	+	-	-	-	-	+/-*
4.8	Хөнжлийн углаа уут	+	+	-	-	-	-	-	-	+/-*
4.9	Ширээний бүтээлэг, салфетка	+	+	+	+	-	-	-	-	+
4.10	Хонгилын хивс/хивсэнцэр	+	+	+	-	-	-	-	-	+
4.11	Тасалгааны хивс	+	+	+	-	-	-	-	-	+
4.12	Хивсний гол	+	+	+	-	-	-	-	-	+

ТАЙЛБАР: * - тусгай вагоныг хөнжлийн углаа уут, нөмрөх даавууны аль нэгээр бэлтгэсэн байна.

5. Вагоны дотоод өрөнхий зохион байгуулалт, эрүүл ахуйн шаардлага

5.1	Гэрэлтүүлэгийн түвшин, лк	Агаарын чийгшил, %	40-60	30-70	40-60
5.2		Тасалгааны хэсэгт	100-150		
5.3		Хонгилд	30-50		
5.4		Ариун цэврийн өрөөнд	50-100		
5.5		Дамжих тавцангийн хэсэгт	20-30		
5.6		Үйлчлэгчийн ажлын өрөөнд	100-150		

В1-р хүснэгтийн үргэлжлэл

5.7		Зуухны өрөөний хянах багажны түвшинд	30-50
5.8	Дулааны температур	Гадна агаарын температур $+30^{\circ}\text{C}$ хүртэл үед	$24 \pm 2^{\circ}\text{C}$
5.9		Гадна агаарын температур $+30^{\circ}\text{C}$ -аас дээш үед	28°C -аас ихгүй
5.10		Шалны температур	8°C -аас багагүй
5.11		Халаалтын систем ажиллаж байх үед вагон доторх дулааны температур	$22 \pm 2^{\circ}\text{C}$
5.12		Халаалтын систем ажиллаж байх үед ариун цэврийн өрөөн доторх дулааны температур	16°C -аас багагүй

Стандарт, хэмжил зүйн газар.

Стандартын мэдээлэл, лавлагаа, сургалтын үндэсний төв. 2018-06-22
Хувилан олшруулахыг хориглоно.

5.13	Вагон доторх агаарын хөдөлгөөний хурд, МС	Зун	0.25								
5.14		Өвөл	0.2								

6. Вагонд заавал байршуулах мэдээлэл

6.1	Зорчигчийн эрх, үүрэг*	+	+	+	+	+	+	-	-	+
6.2	Галт тэрэгний аялалын цагийн хуваарь*/**	+	+	+	+	+	+	+	+	+
6.3	Вагонд үзүүлэх төлбөртэй үйлчилгээний жагсаалт, үнэ*/**	+	+	+	+	+	+	-	-	-
6.4	Галт тэргийг аялалд бэлтгэсэн төмөр зам, байгууллага, аж ахуй нэгжийн нэр*	+	+	+	+	+	+	+	+	+
6.5	Зорчигчийн вагоны үйлчлэгчийн үүрэг*	+	+	+	+	+	+	+	+	+

ТАЙЛБАР: * -Вагонд байршуулах мэдээллүүд нь Монгол хэл дээр бичигдсэн байна.

**Харин олон улсын харилцааны галт тэрэгний вагонд мэдээллийг Монгол, Англи, Орос хэл дээр заавал бичнэ.